



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-18

1.Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	4-18
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
07 дугаар сарын 07-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан;

Чөлөөтэй: Т.Аубакир, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Р.Сэддорж, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг.

Нэг.Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, З.Мэндсайхан, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын

Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Бейсен Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: 1.Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Байгаль орчин болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэхийг хойшлуулав.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 47 минут үргэлжилж, 24 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 16 цаг 40 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Ирцийг ирц та тэндээс авна шүү. Хуралдааны ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна. Болдын Уянгаа гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Батчимэг гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна аа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт. Байгаль орчин болон ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох.

Хоёрт 2 дахь асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсэг танилцуулъя. Ажлын хэсэг оруулъя.

Засгийн газрын хурал давхцаж байгаа учраас сайд ирж чадахгүй байгаа юм байна.

Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч гишүүн Ганхуяг гишүүн танилцуулна.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Ажлын хэсгийн ахлагч маань бас чөлөө авч бас тодорхой ажилтай байгаа учраас миний бие бас санал, дүгнэлтийг танилцуулъя аа.

Байнгын хорооны эрхэм гишүүд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй байнгын хорооны 2025 оны 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатараар гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, М.Ганхүлэг, С.Замира, М.Мандхай, Ундраа, Б.Уянга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүн, Засгийн газрын зээл тусламжийн талаар салбарын 2 яам болон Сангийн яам, Үндэсний аудитын газрын дүгнэлт холбогдох материал мэдээлэлтэй танилцсан.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх багийг байгуулж бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Тамгын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын алба, Хяналт шалгалтын газар, Үндэсний аудитын газар, Сангийн яам, ХХААХҮЯ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Байгаль орчны мэргэшсэн аудиторын холбооны төлөөллийг оролцуулан ажилласан болно. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх баг 2025 оны 1 дүгээр сарын 30, 3 дугаар сарын 13, 3 дугаар сарын 21, 5 дугаар сарын 28-ны өдрүүдэд Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, ХХААХҮЯ, Үндэсний аудитын газар, Сангийн яамнаас мэдээлэл сонсох уулзалтуудыг хийж ажлын хэсгийн тайланг бэлтгэсэн.

Ажлын хэсэг дээрх мэдээлэл тайлантай танилцаад Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарын гадаад зээл тусламжийн зарцуулалттай холбоотой дараах саналыг та бүхэндээ танилцуулж байна аа.

Үүнд:

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарын зээл, тусламжийн ашиглалтыг нэмэгдүүлэх, үлдэгдэл хөрөнгийг хугацаанд нь бүрэн ашиглах төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,

2.Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, зардлын бүтцэд нарийвчилсан шинжилгээ хийж, гадаадын зөвлөх менежментийн зардал зэрэг гадагшаа чиглэсэн үр ашиггүй өндөр зардлыг бууруулах, Дотоодын оролцоог нэмэгдүүлэх зохицуулалтыг сайжруулах.

3.Монгол Улсын хэмжээнд гадаад зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт нэгдсэн хяналт шинжилгээ үнэлгээ хийх оновчтой системийг бий болгох.

Нийт төсөл хөтөлбөрүүдийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулах, стандартчилах ажлыг эрчимжүүлэх.

4.Гадаад зээл тусламжийн мэдээллийг төвлөрүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын одоогийн цахим системийг интеграцчилсан мэдээллийн аюулгүй байдлыг хангасан нэгдсэн цахим мэдээллийн санг байгуулах.

5.Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах үе шатанд үр өгөөж үр нөлөөг тогтвортой хадгалах стратеги боловсруулж үйл ажиллагааг дотоод нөөцөөр үргэлжлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

6.Орон нутгийн байгууллагуудын хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, Гадаад зээл, тусламжийн гэрээ, төслийн менежмент, олон улсын донортой харилцах ур чадвар бүхий мэргэжилтнийг сургах, мэргэшүүлэх.

7.Төсөл, хөтөлбөрийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хэрэгжүүлэх замаар салбар бүрд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж тусгай нэгж бүхий бүтцээс татгалзсан бүтэц зардлыг оновчлох ур ашгийг нэмэгдүүлэх.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүд.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүнд баярлалаа.

Санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Батжаргал гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүний асуулт асууна уу.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас энэ хүмүүс баймаар байгаа юм аа. Энэ олон улсын төсөл хөтөлбөрүүд ихэвчлэн тусгай хамгаалалттай газар нутгуудтай холбоотой асуудлууд хөндөгддөг. Нөгөө талдаа аялал жуулчлалтай холбоотой асуудлууд хөндөгддөг. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл чинь бүр баларлаа. Энэ сая хэлснээр Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гэж хүн байх шиг байна.

Хөвсгөл аймаг Хэнтий аймагт хэрэгжиж байгаа. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл хөтөлбөр. Ингээд бүтэн жилийн хугацаанд тэр Хөвсгөл аймагт баригдаж байгаа Хатгал, Жанхайн хоорондох энэ зам бүр огт явсангүй, 1 дүгээр асуудал.

Бид нар тусгай хамгаалалттай газар нутгууд дээр хэрэгжиж байгаа энэ төсөл хөтөлбөрүүд дээр 1 дүгээрт анхаарахгүй бол зүгээр л мөнгө үрэлгэн байдал чинь өнөөдрийг хүртэл үргэлжилсэн хэвээрээ байна гэдгийг би 1 дүгээрт албан ёсоор та бүхэнд хэлье.

Хоёрдугаарт төслийн баг гэж нэг бужигнуулдаг нөхдүүд байна. Яамнаас ч юм шиг, биш ч юм шиг. Төслийнхөө нэгжээс ч юм шиг, биш ч юм шиг. Олон улсын төсөл хөтөлбөрөөр тухайн улсынх нь хэрэгжүүлж байгаа төсөл учраас зөвлөх үйлчилгээний баг энэ тэр гээд баахан багуудыг гаднаас оруулаад ирдэг тэд нар нь ажиллаад байгаа ч юм шиг, ажиллахгүй байгаа ч юм шиг. Тэгээд би зүгээр сонссон. Энэ 2025 оны 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт гээд маш ерөнхий орж ирж байна. Нэг ч хуралдаагүй гэж ярьж байх шиг байна. Яаж энэ Улсын Их Хурлын гишүүд нь энэ дээр Ганбаатар гишүүн ажлын хэсгийн ахлагч юм байна лээ. Зүгээр ийм нэг санал бичиж оруулж ирээд нэг ч удаа хуралдаагүйгээрээ санал бичиж орж ирээд бүгдээрээ гар хөлийнхөө үсгийг зурчихдаг юм уу яадаг юм.

Энийг би албан ёсоор энэ ажлын хэсгийнхээс бас асуумаар байгаа юм. Маш ерөнхий, маш бөөрөнхий, маш ойлгомжгүй. Ийм л дүгнэлт байна. Энэ дотроос авах ч юм алга. Авахгүй ч юм алга. Яг энийг одоо хэрэгжүүл гээд байгаа юм уу. Битгий хэрэгжүүл гээд байгаа юм уу. Яг яа гээд байгаа нь энэ дээр ерөөсөө ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотой үнэхээр юу ч алга. Аваад өгье гээд ч юм алга. Би бодит байдлыг чинь хэлж байгаа шүү. Тэгээд өөрсдөө ажлаа хийхгүй. Ингээд ажлыг нь заагаад талдаа биш нэг талдаа. Нөгөө талдаа ингээд ийм ийм ороод ирэхээр эргээд хэлчихээр бид нарыг Байнгын хорооны хурал дээр загналаа энэ тэр гээд энд тэнд очоод аавдаа эрхэлж байгаа хүүхэд шиг аав ээждээ эрхэлж байгаа хүүхэд шиг очоод юм яриад яваад байх юм.

Та нар наад хариуцсан ажлаа хийвэл хий. Хийхгүй бол наад сандал суудлаа чөлөөлж өгөх хэрэгтэй. Хариулт авъя.

Б.Бейсен: Дэлгэрэнгүй тайланг гишүүдийн групп дээр тавьчихсан байгаа. 8 номер хариулах уу?

Б.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Энэ тогтвортой аялал жуулчлал гээд сая БОАЖ-ын сайд дээр хэрэгжиж байгаад Засгийн газрын шинэ бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор Соёл, спорт, аялал жуулчлалын яам руу шилжсэн ийм төсөл байгаа. Энэ төсөл маань гишүүний хэлж байгаа үнэн. Энэ төсөл эхлээд олон жил болж байгаа энэ төслийн бүүр 2 дугаар үе шатыг эхлүүлэх саналыг хүртэл Улсын Их Хурал руу орж ирээд энэ төслийн эхний хэрэгжилттэй холбоотойгоор ингээд Их Хурлын аюулгүй байдал бусад Байнгын хороон дээр энэ төслийн дараагийн үе шат нь дэмжигдээгүй.

Тэгээд Хэнтий аймаг дээр хэрэгжиж байгаа энэ аялал жуулчлалын цогцолборын төсөвт өртөг нэмэгдсэн бусад шалтгаанаар энэ төсөл маань өөрөө ингээд бас төсөвт өртгөө нэмүүлэх ийм асуудал яригдсан. Тэгээд үүнийг манай Сангийн яам дэмжээгүй байгаа. Тэгээд сая гишүүний хэлж байгаа үнэн. Төсөл хэрэгжүүлэх нэгж гэж байгаа мөн яаман дээр нь тухайн төслийг хэрэгжүүлж байгаа ийм төслийн захирал гээд хүмүүс байдаг. Тэгээд энэ хүмүүс маань тухайн төслийнхөө хэрэгжилтийг бүрэн хариуцаад явах ёстой байгаа. Яах вэ манай Сангийн яаман дээр бол яг хийж байгаа хяналт, санхүүгийн хяналтыг хийгээд явж байгаа. Тэгэхдээ төслийн хэрэгжилт ер нь бол төлөвлөсөн хугацаанаасаа хоцрогдолтой мөн ингээд ажил нь удааширсан явж байгаа.

Тэгэхээр бас энэ БОАЖЯ-н дээр хэрэгжихээ больсон төсөл байгаа. Тэгээд Соёл, спорт, аялал жуулчлалын яам руу шилжсэн гэсэн үг байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн нэмж хариулах уу?

М.Ганхүлэг: Ажлын хэсэг 2025 оны 1 сарын 21-ний өдрийн удирдамжаар ажлаа, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэ хугацаанд үндсэндээ ажлын бас дэд ажлын хэсэг дээр гол хуралдаан үйл ажиллагаанууд явсан. Миний түрүүнд дурдсанчлан бол дэмжлэг үзүүлэх үндсэндээ баг маань бүтэн ажилласан. 2025 оны 1 сарын 30, 3 сарын 13, 3 сарын 21, 5 сарын 28-ны өдрүүдэд үндсэндээ бас ажиллаж тодорхой санал, дүгнэлтүүдийг бас нэлээн бас олон материалыг бас бэлтгэсэн байгаа.

Энэхүү материалыг бас Байнгын хорооны групп дээр гишүүдэд бас цахимаар хүргүүлсэн байгаа. Дэлгэрэнгүй бас танилцах боломжтой. Ажлын хэсгийн санал, дүгнэлт яг төсөл тус бүрээс гэхээсээ илүүтэй ер нь бас нийтлэгдээ зарчим ямар байх вэ гэдэг рүү чиглэсэн.

Стандартуудыг илүү тодорхой болгоё. Хэмжиж байгаа тэр шалгуур үзүүлэлтүүдээ бас илүү тодорхой болгоё. Үр дүнг тооцож байгаа энэ процессоо бас яамдууд болон мэргэжлийнхэн бас илүү сайжруулах ийм гол агуулгуудыг тогтоолын төсөлд бас тусгаад.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн торуулъя.

Б.Бат-Эрдэнэ: Сангийн яамаа би хаанах, хаашаа шилжсэн гэж ерөөсөө асуугаагүй шүү дээ. Наадхыг чинь би маш сайн мэдэж байгаа. Соёлын яам дээр очсон Соёлын яамныхан бид нар ийм том төсөл хөтөлбөр хийж чадахгүй үзээгүй гэж хэлээд зогсоочихсон юм байна лээ. Одоо нэг жил болж байна. Яг нэг жил болж байна. Тэгээд энэ дээр яах юм бэ? Та бүхний хариулт хэлээд байгаа зүйл дээр ялангуяа энэ 2025 оны 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлт. Ганхүлэг гишүүнээ одоо та өөрөө Хэнтий аймгийнх. Хэнтий аймаг дээр төсөл зогсчоод байна шүү дээ. Явахгүй байна одоо яах вэ? Энэ санал, дүгнэлт гарч байгаа гол утга учир нь энэ төсөл хөтөлбөрүүдийг л явуулах ёстой биз дээ.

Төсөл хөтөлбөрүүдээ үр ашигтай байлгах ёстой. Тэгээд энийгээ л хэдүүлээ хийгээд явъя л гэдэг санаа шүү дээ. Тэгээд энэ тогтоолоо та хэд маань нэлээн нарийвчилж оруулж өгөхгүй бол ийм байдалтай цаашаа явахгүй л дээ. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийнх илүү.

Б.Бейсен: 8 номер хариулъя.

Б.Ганзориг: Гишүүний асуултад хариулъя.

Яг энэ ажлын хэсгийн бас дүгнэлт дээр та харах юм яг эхний нэг дэх ажил дээр яг саяын таны хэлдэг саналыг бол маш тодорхой бичсэн байгаа. Тухайлбал энэ байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарын зээл, тусламжийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тэгээд энэ үлдэгдэл хөрөнгийг хугацаанд нь бүрэн ашиглах гэдэг энэ санал өөрөө яг энэ төслүүдийн та бүхэн мэдэж байгаа энэ 2025 оны төсөв дээр сая яах вэ тодотгол маань 3 дугаар хэлэлцүүлгээ Их Хурал дээр хийчихлээ.

Тэрнээс өмнө бол алдагдалгүй төсөв гэдгээр явж байсан. Алдагдалгүй төсвийн хүрээнд бол гадаад зээлийн ашиглалтыг бол 1.5 их наядаар ингээд баталсан байсан. Энэ дээр бол 89 төсөл энэ 1.5 их наядыг хувааж авах хүрээнд бүх төслүүдийн санхүүжилт бол ер нь тодорхой хэмжээгээр хязгаарлалттай байсан. Одоо бол сая бид нар алдагдалгүй төсөв гэдэг чиглэл рүүгээ явж байгаа учраас алдагдалтай төсөв гэдэг чиглэл рүүгээ явж байгаа учраас 1.3 их наядын ингээд алдагдалтай төсвийг 3 дахь өдөр Их Хурал маань 4 дүгээр хэлэлцүүлгийг хийх гэж байх шиг байна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Сангийн яамаа хэдүүлээ ингээд байгаа байхгүй юу. Энэ байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбоотой асуудлыг л хэлэлцэж байгаа гэж би ойлгож байгаа. Өнөөдөр та бүхнээс үл шалтгаалсан байдлаар Соёлын яаман дээр чинь тэр тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг аудит оруулчихсан юм байна лээ шүү дээ. Дотоод аудит та нар дээр нь нэг юм яриад байдаг. Яамдууд чинь дотор талдаа дахиад дотоод аудитаараа аудит оруулаад байдаг байж болдог юм уу, болох юм уу? Тэгээд ингээд байвал наад төсөл хөтөлбөр чинь хэрэгжихгүй. Хий хоосон мөнгө төгрөг зарлагадсаар л байгаа. Энэ Монгол Улсын татвар төлөгчдийн мөнгө энд төлөгдөж байгаа. Бид нар хүссэн ч, эс хүссэн ч тэр төсөл хэрэгжсэн ч эс хэрэгжсэн ч төлдөг зээлийн үндсэн төлбөр хүүгээс чөлөөлөгдөхгүй.

Гэтэл яамдууд чинь дотор талдаа дотоод аудит хийгээд бүх юмыг чинь зогсоогоод байна шүү дээ. Тэгээд энийг яах вэ л гэж би асуугаад байгаа юм. Санаа нь, яаж төсөл хөтөлбөрийг чинь хэрэгжүүлэх юм бэ? Цаадах чинь өөр процесс яваад байна шүү дээ.

Б.Бейсен: Хэдэн номер 8 номер.

Б.Ганзориг: АХБ-ны уг уг төслийг өнгөрсөн оны 11 сард яг албан ёсоор бид нар нөгөө энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор шилжүүлэх хүсэлтийг өгсөн. Тэгээд энэ процесс маань өөрөө бас АХБ-ан дээр яг таны хэлдгээр тухайн яаман дээр яг энэ төслөө хэрэгжүүлж чадах юм уу үгүй юу гэдэг үнэлгээг бараг 6 сар орчим хийгдсэн байгаа. Тэр яг манай Монголын талаас хамааралгүйгээр АХБ тухайн төслийг Соёл, спорт, аялал жуулчлалын салбар маань өөрөө хэрэгжүүлж чадах уу үгүй юу гэдэг үнэлгээг хийсэн. Энэ үнэлгээ хийгдэж дуусаад албан ёсоор шилжсэн байгаа. Тэгээд энэ шилжих процессын хувьд бид нар боловсор Байгаль орчны яам руу бас манай

Сангийн яамнаас явсан тодорхой бичгүүд байдаг. Энэ төслүүдийг хийж шилжилт хийгдэх хугацаанд саадгүй хэрэгжүүл гэсэн.

Мэдээж хүлээж авсан яам маань дотроо өөрсдөө тэр тухайн төсөл ямар хэрэгжилттэй явж байсан дээр үнэлгээ хийх бүрэн эрх нь байгаа.

Б.Бейсен: Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Манай улсад гаднын зээл тусламж маш их орж ирдэг ээ. Ялангуяа энэ байгаль орчны чиглэлээр ХАА-н чиглэлээр бол жил болгон маш их хэмжээний зээл тусламжууд орж ирдэг ээ. Гаднын зээл тусламж авах асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор оруулаад ингээд эрхээ аваад л гараад явчихдаг. Улсын Их Хурлын гишүүд мэдээлэл их дутмаг байдаг. Гаднын зээл тусламж яг юунд авах гэж байгаа юм хэрэгцээ шаардлага нь юу юм бэ, хэрхэн үр дүнтэй хэрэгжсэн юм бэ, үлдэгдэл нь ямар байгаа юм бэ. Тухайлах юм бол аль бүс нутагт, аль аймагт, ямар төслүүдэд гаднын зээл тусламжийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм бэ. Зөв оновчтой хуваарилах асуудал гээд олон асуудлууд Их Хурлын гишүүдээс мэдээлэл сайн байдаггүйгээс энэ зарцуулалтыг сайн мэдэхгүй. Ялангуяа хуваарилалтыг сайн мэдэхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас энэ гаднын зээл тусламжийг хаана юунд зарцуулахыг хаана шийдээд байгаа юм бэ. Тухайлах юм бол өнгөрсөн хугацаанд харж байхад говийн бүсэд нэн шаардлагатай цөлжилтийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бэлчээрийг сайжруулах гэсэн ийм чиглэлээр орж байгаа зээл тусламжууд говийн бүсдээ хэрэгжихгүйгээр хангайн бүс бэлчээр ургамал аль болох сайтай ус сайтай ийм газрууд хэрэгжээд явдаг ийм асуудал бас гардаг. Тухайлах юм бол бас малын хашаа, саравч сайжруулна гээд л Өвөрхангай, Архангай аймгууд хэрэгжүүлнэ гээд л өмнө нь Байнгын хороонд орж ирж байсан. Говийн бүсэд бас байхгүй. Тийм учраас энэ гаднын зээл тусламжийг аль бүс нутагт, хаана хэрэгжүүлэх гэдгийг хаана шийдээд байдаг юм бэ? Энэ талаар нэг юу мэдээлэл өгөөч ээ.

Мөн энэ гаднын зээл тусламж хэрхэн үр дүнтэй яаж хэрэгжив гэдгийг энэ Байнгын хороондоо эргэж тайлагнаж байна уу үгүй юу. Бид нар чинь эрхийг нь л өгөөд л гаргачихдаг болохоос биш үр дүн, гүйцэтгэл тэд нарыг нь ерөөсөө эргэж бид нарт танилцуулдаг мэдэгддэг ийм зүйл байна уу үгүй юу. Цаашдаа энэ Байнгын хороогоор энэ гаднын зээл тусламжийн зөв оновчтой хуваарилалт, энэ ашиглалт, үр дүнг нь зайлшгүй сонсдог байх ийм шаардлагатай байгаа юм. Тэгээд сая ажлын хэсгийн ахлагчийн Засгийн газрын тогтоолыг уншихад энэ дээр энэ чиглэлийн юм ер нь байгаа юм уу үгүй юм уу? Гаднын зээл тусламжийн хэрэгцээ шаардлага, зөв оновчтой хуваарилалт, үр дүн эргээд Байнгын хороо, Улсын Их Хурал, гишүүдэд тайлагнадаг байдал. Энэ чиглэлийн юмыг нь юунд тусгаж өгсөн үү үгүй юу гэсэн ийм асуултууд байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Наранбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь зээл тусламжтай холбогдолтой шалгуур үзүүлэлттэй холбогдолтой асуудлууд бас нэлээн бас маргаантай байна гэдэг агуулга ажлын хэсгийн дүгнэлтэд гарсан. Үүнтэй холбогдолтой шалгуур үзүүлэлтийг илүү оновчтой болгох яг

хэрэгжиж байгаа төслүүд дээр явж байгаа тэр үнэлгээ ямар байдалтай үр дүнгээ өгч байгаа гэдэг энэ асуудлуудыг илүү сайжруулах буцаагаад Байнгын хороонд үндсэндээ тайлагнах гэдэг энэ 3 агуулга гурвуулаа ерөнхийдөө тогтоолын төслийн агуулга дээр орсон байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: 8 номер хариулаадах.

Б.Ганзориг: Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулъя аа. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Яах вэ ер нь гишүүний асуусан эхний асуулт энэ гадаад зээл тусламжийн төслүүдийг хаана хэрэгжүүлэх мөн шийдвэрийг хаана гаргаж байна вэ гэсэн асуулт байгаа. Энэ бол яах вэ тухайн төслийг нь анх дизайныг нь боловсруулах шатад бид нар олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтайгаа зөвшилцөөд явдаг. Ингээд зөвшилцсөнийхөө дараа яг тухайн төслийг хаана хэрэгжүүлэх гэж байгаа, яах гэж байгаа гэдгээ яг таны хэлснээр бид нар Их Хурлын 3 Байнгын хороогоор оруулж хэлэлцүүлж байгаа. Үүний дараа эрхээ авчхаад мөн дараа нь Улсын Их Хурлаар тухайн хэлэлцээрийг бид нар Их Хурлаар орж соёрхон батлуулж байгаа. Бүх зээлийн хэлэлцээрүүд Их Хурлаар ер нь шийдэх хамгийн эцсийн шийдвэр нь гарч байгаа гэж хэлмээр байна.

Хоёр дахь дээр нь яах вэ үр дүн дээр хэрэгжилтийг эргэж Их Хуралд танилцуулж байгаа юу гэдэг дээр энэ 2025 оны төсвийн хувьд өнгөрсөн онд Их хурлын 81 мөн 54 дүгээр тогтоолууд гарсан. Энэ тогтоолууд дээр Их Хуралд энэ гадаад зээл тусламжийн төслүүдийн.

Б.Бейсен: Гүйцээж хариулъя. Сая миний дурдсан Их Хурлын тогтоолууд дээр Улсын Их хуралд эргэж танилцуулаарай гэсэн чиглэл өгчихсөн. Үүний дагуу бид нар Их Хурлын Булгантуяа дэд даргаар ахлуулсан ажлын хэсэгт гадаад зээл тусламжийн төслүүдийн талаар хэд хэдэн удаа бас танилцуулга хийгээд энэ тухайн ажлын хэсгээс санал, дүгнэлтүүд боловсруулагдаад Их Хуралд танилцуулагдаж байгаа. Яах вэ өмнө нь бол Их Хуралд эргэж танилцуулахаар чиглэл өгөгдсөн тохиолдол бас байгаа. Яах вэ Их Хурлын бид нар батлагдсан яг соёрхон баталсан зээлийн хүрээнд төслүүдээ Засгийн газар дээр хэрэгжүүлээд явж байгаа гэсэн үг.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгээд би бол товчхондоо ингэж л хэлээд байгаа юм. Гаднын энэ өндөр хүүтэй зээл тусламж чинь байгаа олохгүй. Нарийн ярих юм бол тухайн Байгаль орчин, ХАА-н сайд, удирдлага, дарга нарын нутаг руу ч юм уу тойрог руу явчихдаг.

Мөн тэр төслийн нэгж цааш нь хаана хуваарилах хэрхэн зарцуулахыг бас шийдчихдэг ийм асуудлууд байгаа шүү. Жинхэнэ яг хэрэгжих газартаа очдоггүй шүү. Би түрүүн хэлсэн шүү дээ. Өмнө нь говийн бүсэд үр дүнтэй хэрэгжсэн ийм гаднын зээл тусламж ерөөсөө байхгүй. Хамгийн их цөлжиж байгаа, хамгийн их усгүй болж байгаа хамгийн их бэлчээр нутаггүй болж байгаа газар руу очдоггүй.

Тэгсэн мөртөө аль бэлчээртээ шим тэжээлтэй устай газрууд руу явчихдаг ийм тохиолдлууд байгаа учраас энэ дээр цаашдаа анхаараарай гээд тэгээд энэ Засгийн газрын чиглэл өгөх тогтоол дараа нь яригдах юм байна. Тэрэн дээр саналаа хэлье.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүний асуулт асууя.

З.Мэндсайхан: Энэ салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар дүгнэлт гарчээ, Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Тэгээд энэ Засгийн газарт өгч байгаа чиглэлийн нэг дээр байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн болон ХХААХҮ-ийн салбарын зээл, тусламжийн ашиглалтыг нэмэгдүүлж, үлдэгдэл хөрөнгийг бүрэн ашиглая. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх гэж тусгаж өгсөн байна. Тэгээд 1 ийм заалтыг аргаа барсан заалт байхгүй юу. Яагаад гэхээр энэ төсөл хөтөлбөр хэрэгжихгүй байгаа шалтгааны чинь үндсэн эзэд нь Засгийн газрын гишүүд байхгүй юу. Тэгээд тэд нарыг эрчимжүүл гэж өгөөд байгаа юм. Ховд аймаг дээр бид нар АХБ-ны усалгаатай газар тариалангийн хүрээнд 2500 га газрыг усжуулах ингээд баруун бүсийн хүнсний ногоогоор хангах энэ төслийг хэрэгжүүлэхээр болсон. Энийг миний бие би сайд байхдаа бас дэмжиж явуулж байсан. Яагаад дэмжиж байсан гэхээр энэ бол тухайн төсөл хөтөлбөрийг анх Азийн хөгжлийн банк Монголд хэрэгжүүлэх төслөө ТЭЗҮ газар зүйн заалт дээр нь судалгаа хийж үзээд энэ энэ аймгууд дээр ийм ийм ажлуудыг хийх нь зүйтэй юм гээд шийдчихсэн асуудал. Түүнээс биш Мэндсайхан гэдэг хүн шийдээгүй ээ.

Энэ ажлыг аль нэг сайд нь авангуутаа өөрчилчихдөг. Ингэхээр чинь энэ төсөл хөтөлбөр чинь хугацаандаа хэрэгжихгүй байгаа юм. Тэгээд хэрэгжихгүй байгаа учраас бид нар дахиад хэрэгжүүл гэдэг чиглэл өгөх гээд сууж байна л даа. Энхбаяр сайд одоо энэ дээр баруун бүсийн аймаг тэр дундаа Ховд аймгийнханд хүнсний ногоо идэх шаардлага байхгүй гэдэг маягаар энэ усалгаатай газар тариалангийн төсөл хөтөлбөрийг өөрчилж төвийн бүс рүү шилжүүлсэн. Дархан, Сэлэнгийн бүс рүү. Тэгээд Монгол Улсын ХААЯ бол улсын хэмжээнд ХАА-н салбарын бодлогыг авч явах ёстой болохоос биш төвийн бүсийн бодлогыг авч явдаг ийм байх юм наадхаа одоо тэндээ зарлаад энэ бүс нутгуудад дутагдаад байгаа ХАА-н салбарын бодлогыг хэрэгжүүлэх байгууллагаа тодорхой болгож өг гэж хэлмээр байгаа юм. Сайд нь зөвхөн газар тариалангийн бүс буюу төвийн бүсээ л ярьдаг. Баруун бүс, төвийн бүс энэ зүүн бүсийн иргэд, Өмнөговь, өмнийн говийн бүсийн иргэд хүнсний ногоо, ХАА-н бодлогоор гадна үлдэж байдаг. Энэ ямар учиртай юм бэ? Яагаад энэ хөтөлбөрийг зогсоосон бэ? Төсөл хөтөлбөрүүдийн гаднын зээл тусламжуудын хэрэгжихгүй байгаа шалтгаан бол тухайн сайд нарын үйл ажиллагаанаас болж гацаад байгаа болохоос биш энэ төслийн чинь хэрэгжүүлэх гээд явж байгаа яам, энэ төслийн мэргэжилтнүүдээс болоод байгаа асуудал огт биш. Ингээд бодлого тогтворгүй байхаар гаднын зээл тусламжууд үр дүнгүй, өгөөжгүй болж хувираад цаг хугацааны хувьд дуусахгүй болчихож байгаа юм. Тэгээд энэ дээр би хариулт авъя гэж бодож байна.

Б.Бейсен: 9 номер Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Мэндсайхан гишүүний асуултад хариулт өгье.

ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгээд АХБ-ны санхүүжилттэй Энэ 42 сая долларын санхүүжилтээр усалгаатай газар тариалангийн талбайг нэмэгдүүлэх гээд нийтдээ 7700 га газраар усалгаатай талбайг нэмэгдүүлэх ийм төсөл хэрэгжиж эхэлсэн. Одоо төслийн хэрэгжилт бол 83 хувьтай явж байгаа. Тэгэхээр энэ 7 аймгийн 14 байршилд усалтын систем байгуулах ийм төсөл байсан. Эндээс 7 аймгийн 14 сумаас 2 сумын төсөл нь одоохондоо хэрэгжээгүй үлдсэн тухайлах юм бол Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн

сумын 3 мянган га, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын 2 мянган га-гийн услалтын систем.

Ингээд төсөл эхлэхдээ АХБ-ны судалгааны баг ажиллаад нийтдээ төрийн болон орон нутгийн өмчлөлтэй 47 байршилд бид нар байршлыг гаргаж өгсөн. Энэ дээр судалгаа хийгдээд энэ 7 аймгийн 14 сум шалгарсан. Төслийн хэрэгжилтийн явцад дахин үнэлгээ хийгээд энэ 2 төсөл дээр Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэнгийнх бол нутгийн иргэд нь энэ дээр бас төсөл хэрэгжүүлэх шаардлагагүй гэдэг эсэргүүцлийн дагуу зогссон. Эрдэнэбүрэн сум дээр дахин үнэлгээ хийгдээд энэ төсөл зогссон. Тэгэхдээ энэ төсвийг нь өөр аймгууд дээр судалгаа хийгдэх маягаар ингээд үргэлжлүүлээд явж байгаа гээд хэлье ээ.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

3.Мэндсайхан: Харин гаднын зээл тусламжууд үр дүнгүй болоод байгаа шалтгаан яг таны хариулт байхгүй юу. Азийн хөгжлийн банк, Мэргэжлийн байгууллага нь өөрөө судалгаа хийгээд энэ бүс нутаг, энэ сум дээр, энэ бүс нутгийн иргэдэд шаардлагатай төсөл хөтөлбөр байна гээд хэрэгжүүлэхээр сайд нь болохгүй төвийн бүсэд хэрэгжүүлнэ гээд татаад авчихсан. Тэгээд одоо тэрнийхээ дагуу судалгаа хийгээд нэг ажлыг, нэг сайдын үзэмжээс болж 2, 3 удаа хийнэ гэдэг бол энэ төсөл хөтөлбөрийн чинь хэрэгжихгүй байгаа үндсэн шалтгаан. Би танай яамныханд дахиад хэлье.

Монгол Улсын ХАА-н салбар гэдэг бол улсын хэмжээний салбар бодлого явуулдаг Засгийн газрын эрх бүхий байгууллага шүү. Түүнээс биш төвийн бүсэд явуулдаг түүний гадна талд бусад бүсүүд нь үлдчихээд ингээд байж байдаг ийм асуудал байхгүй шүү. Баруун бүс нутагт Монгол Улсын иргэд Засгийн газрын тэр дундаа ХАА-н хүнсний бодлогын үр өгөөжийг хүртэж байх ёстой, тэр бодлогод хамрагдаж байх ёстой. Тэр бүс нутагт байснаараа Энхбаяр сайдын тойрог бишээрээ энэ талбайн бодлогын гадна талд үзэж болохгүй гэдгийг би хатуу хэлье.

Б.Бейсен: Асуулт уу? Санал уу? Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Байгаль орчин, хүнс, хөдөө аж хуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламжийн үр өгөөж дээр ажлын хэсэг гараад ажилласан байна. Судалгаа юмнууд хийгдсэн байх аа? Би тэгж ойлгож байна. Байдлаа нэг олж хараад цаашид баримтлах чиглэл юмнуудаа тодорхойлсон Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол орж ирж байгаа юм байна. Энэ уг нь жоохон амьтай байвал зүгээр гэж би ингэж хараад байна л даа. Ерөөсөө энэ 2 салбар дээр чинь хэрэгжиж байгаа төсөл чинь хумигдчихсан шүү дээ. Бид хэд энийг чинь нэг жил гарны өмнө билүү авч хэлэлцсэн. ХАА-н салбар дээр зургаа үлдэл үү хэд ч билээ тийм л төсөл хөтөлбөр байгаа, санхүүжилттэй.

Тэгэхээр цаашид яах юм бэ гэдэг асуудал. Энэ 2 салбар дээрээ байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбар дээрээ нэг иж бүрэн үнэлгээ юмнууд хиймээр байна. Тэгээд чухам аль чиглэл дээр гаднын зээл тусламж авч ашиглах юм тэрний үр өгөөж нь юу хүлээгээд байгаа юм гэдэг юмаа тодорхой болгомоор байна.

Би Магнайсүрэнг Аудитын газрын даргаар тавигдахдаа хэлсэн үг байгаад байгаа юм. Том төслүүдийг хэрэгжихээс нь өмнө аудит хийе гэдэг. Яг тэрэн шиг энэ ер нь Монгол Улсад хэрэгжүүлэх гээд байгаа энэ том төслүүдийг урьдчилсан

үнэлгээ дүгнэлт хийгээд нөлөөлөл, үр дагавар бүх юмыг нь тооцож үзээд яг энэ чиглэл дээр нь авах ёстой юм байна гэдэг юмаа тогтож аваад тэрэн дээрээ гаднын зээл тусламжаа авч ажилладаг баймаар байна аа.

Тийм учраас энэ тал дээр Сангийн яам, ХХААХҮЯ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ер нь ямархуу бодлого чиглэлтэй байгаад байгаа юм. Энүүнийг би сонсмоор байна гэж.

Хоёр дахь зүйл. Бид зөндөө юм хэрэгжүүлсэн. Юм үлдэж өгөхгүй байна. Тэгэхээр энэ хэрэгжүүлсэн төслүүд санхүүжилт нь дуусдаг ч байлаа гэсэн энэ хүрээнд хийгдсэн тэр сайн арга барил, сайн менежмент, тэр тогтолцоо энэ бүх юмыг үндэснийхээ хэмжээнд энэ салбартаа авч үлдэх ёстой юм аа. Тийм учраас энэ салбаруудын эрх зүйн орчинд нь, стандартад нь, заавар зөвлөмжид нь яг тусгаж оруулж авч үлддэг байх ёстой. Энүүнийг хийх талаар ер нь Монгол яаж ажиллаад байгаа юм бэ гэдэг нэг ийм зүйл байна. Энийг ер нь цаашид яая гэж бодоод байна вэ гэж.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл бол яах аргагүй энэ хэд хэдэн салбар дээр жоохон гаднын боломжууд байна. Энийг хэдүүлээ авч үлдмээр байна хиймээр байна гэж. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулъя гээд. Дүйцүүлсэн хамгаалалтын асуудал энэ дээр яригдаад томоохон хөрөнгө мөнгөтэй корпорацууд, өөрийнхөө ялгаруулж байгаа хүлэмжийн хийтэй дүйцэх хэмжээний.

Б.Бейсен: Батжаргал гишүүн гэрчээр асууя.

Ж.Батжаргал: Хүлэмжийн хийн ялгарлын бууруулъя гээд бүүр тов тодорхой хөрөнгө тавьчаад байна. Тийм учраас Монгол энэ цөлжилттэйгөө тэмцэхэд гэдэг юм уу бас энэ хүлэмжийн хийн шингэлтийг нэмэгдүүлэх тэр ногоон ургамалжсан массаа нэмэгдүүлэхийн тулд энэ хөрөнгөөс ахиухан олж авч татмаар байгаа юм аа. Энэ тал дээр ер нь ямар бодлого санаанууд байгаад байгаа юм бэ гэж. Аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд хэдүүлээ олон ярьж байгаа юм. Ер нь аль ч цаг үед бас үзэмжээр гэдэг юм уу бодлого зөрж зохицуулагдаад явчихсан л даа. Тэгэхээр бүс нутгуудаа тогтоогоод тэнд ямар эвент дээр тулгуурлаж аялал жуулчлал хөгжих юм бэ? Тэр бодлого зорилтоо их тодорхой болгоод төр хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурлаж хувийн хэвшлийнхээ чиглэлээр хийж байгаа ажлыг нь дэмжээд явчихмаар байгаа юм аа.

Төр жоохон хөрөнгөө энэ рүү чиглүүлмээр байгаад байгаа юм. Алтай Таван богдыг.

Б.Бейсен: Хариулт. 8 номер хариулъя.

Б.Ганзориг: Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид нар ингээд гаднын зээл тусламжийн төслүүдийн хувьд ер нь хэрэгжилтийн асуудал хүндэрсэн байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор бид нар ер нь цаашдаа авах хэд хэдэн арга хэмжээний Их Хурлын тогтоол түрүүний ярьсан түрүүн миний дурдсан өнгөрсөн жилийн 81, 54 дүгээр тогтоолуудын дагуу бас хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлээд явж байгаа. Тухайлбал хэрэгжээд явж байгаа төслүүдийнхээ хувьд бид нар эрэмбэлээд

зарим нэг үйл ажиллагааны хувьд зайлшгүй шаардлагагүй зардлуудыг нь хасъя гээд хасаж байгаа. Зарим нэг үйл ажиллагаа нь амжилтгүй явж байгаа төслүүдийг зогсоох арга хэмжээ авч байгаа.

Зарим 1 сая бас энэ ажлын хэсгийн дүгнэлт дээр орсон байгаа нэгжүүдийг нэгтгэж урсгал зардлыг бас бууруулах шаардлагагүй, зөвлөх үйлчилгээний зардлуудыг ингээд цогцлоох гэсэн. Энэ ажлуудыг Сангийн яаман дээр яг хийгээд явж байна. Үүний хүрээнд бид нар нийтдээ 173.4 тэрбум төгрөгийн ийм нийтдээ 14 төслийн 54 орчим ажил үйлчилгээг ингээд хойшлуулах заримыг нь зогсоох арга хэмжээг авчихсан ажиллаж байна. Өнөөдрийн Засгийн газрын хурлаар арай амжсангүй. Энэ 3 дахь өдрийн Засгийн газрын хурлаар орох байх. Бид нар бас энэ төсөл хэрэгжүүлэх нэгжүүд тэгээд зөвлөх үйлчилгээний зардлуудыг бууруулах хүрээнд нийтдээ 46 төсөл хэрэгжүүлэх нэгжийг 16 нэгж болгож бууруулаад ингээд үйл ажиллагааны урсгал зардлыг 40 орчим хувиар хэмнэх ийм арга хэмжээнүүдийг хэрэгжиж байгаа төслүүдийн хувьд аваад явж байгаа. Одоо шинээр хэрэгжих төслүүдийн хувьд хэрхэн үнэлэх вэ? Энэ урт дунд хугацааны бодлогын бичиг баримт дээр туссан төслүүдийг гаднын зээл тусламжийн төслүүдээр хэрэгжүүлэх үү гэдэг асуудал үндсэндээ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр ингээд бодлогын бичиг баримтуудтайгаа уялдуулаад явж байгаа. Гэхдээ гол гадаадын зээл тусламжийн өрийн удирдлагын стратеги дээр бас батлагдсанаар зөвхөн дэд бүтэц бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих төслүүд рүү шилжүүлэх ёстой гэсэн чиглэлийг баримталж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас манай Сангийн яаман дээр энэ энэ нийтдээ хэлэлцээрт явж байгаа 17 орчим төсөл байна. Энэ төслүүдийг нийтдээ бараг 1.7 тэрбум долларын ийм төсөвт өртөгтэй ажлууд явж байгаа. Эд нарыг бас дотор нь эрэмбэлэх заримыг нь бид нар хөгжлийн түнш байгууллагуудтайгаа хэрэгжүүлэхгүй болих гэсэн энэ чиглэлүүдээр бас ингээд ажиллаж байгаа. Тэгэхдээ яах вэ энэ Их Хурлаас Засгийн газарт өгч байгаа энэ чиглэлд өгч байгаа тогтоол дээр энэ ерөнхий санаанууд нь орсон учраас энийг манай Сангийн яам дэмжээд явж байгаа.

Баярлалаа.

Б.Бейсен: 9 номер Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тийм тэгэхээр бас тантай санал нэг байгаа. Ер нь бол тухайн төслөөр 20 сая долларын төсөл хэрэгжүүлээд тэрүүгээр бүх асуудлыг салбар шийднэ гэдэг бол байж болохгүй асуудал. Тэгэхээр энэ төсөл хэрэгжээд тэрүүгээрээ тодорхой хэмжээний бид нар цаашдаа энэ жишиг болоод явах энэ гарын авлагуудыг зөвлөмжүүдийг сургалтуудыг тухайн төсөл хэрэгжсэн орон нутгийн ногоочид фермерүүдэд үлдээх энэ чиглэлд нэлээд анхаарч ажиллаж байгаа. Бид бол тухайлах юм бол Дэлхийн банкны энэ манай салбарт хэрэгжиж байгаа МАА-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд гэх юм бол 35 дэд төслүүдийг энэ төсөл хэрэгжиж байгаа 17 аймгийн 80 сумд бас хэрэгжүүлж энийгээ цаашаа жишиг болгох талд нь анхаарч ажиллаж байгаа.

Дээрээс нь бас 4 ч тийм тэжээлийн зангилаа үйлдвэрийг байгуулж энэ жишгээр тэжээлийнхээ үйлдвэрлэлийг нэмэгдүүлье гэх мэтчилэн цаашдаа энэ төсөл хэрэгжээд дуусах биш үргэлжлэх.

Б.Бейсен: 9 номер.

Ц.Болорчулуун: Үргэлжлээд явах талд нь бид нар бас нэлээд анхаарал тавьж ингэж ажиллаж байгаа. Одоо бол шинээр хэрэгжиж байгаа төслүүд дээр мэдээж энэ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ногоон байх гэсэн энэ олон том шалгууруудыг нэлээд тавьж байгаа. Энэ шалгуур дээр хамгийн түрүүн хувийн хэвшлүүд өөрсдийнхөө гаднын донор байгууллагаас авч байгаа санхүүжилт дээр нэлээд түлхүү түрүүлээд ороод явж байгаа. Яг Засгийн газраар хэрэгжих төслүүд дээр бид нар бас энэ шалгуур үзүүлэлт дээр нь Эдийн засгийн хөгжлийн яамтай бас тодорхой ажлуудыг хамтарч зохион байгуулж ажиллаж байгаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тэгээд энэ салбаруудаас экспортын үзэл баримтлалтай валют дотогшлуулахаар зүйлүүдээ тэргүүн ээлжид харж тэр олон улсын эвсэл гэдэг юм уу тэр байгууллагуудтай нь хамтрах тухай асуудал байгаад байгаа юм. Тэр Тогтвортой ноос ноолуурын холбоо гэж тэр байгууллагатай бид илүү их хамтарч байж л энэ ноолуурыг Европ руу бас нэлээн гайгүй үнэтэй боловсруулалтын түвшин ахиулж гаргах бололцоо бүрдэх юм байна лээ. Энэ бол бас тэр тогтвортой ноос ноолуурын холбооноос Монголтой хамтраад 100 гаруй сум болчихож байгаа байх. Би тэгж бодоод байна. Хэрэгжүүлээд яваад байгаа юм. Энэ мэтчилэнгээр үр дүн бүх юм нь яг энэ салбартаа байж байгаа улсад өгөөж нь өгөхөөр ийм юмнуудыг бид илүүтэй түшиж ажилламаар ийм зүйлүүд харагдаад байгаа юм аа.

Тийм учраас энэ салбаруудад хэрэгжүүлэх гээд байгаа юмнуудаа ингэж л хэдүүлээ нэг эрэмбэлж цэгцэлж.

Б.Бейсен: Батжаргал гишүүнээс асууя.

Ж.Батжаргал: Асуудал байна. Зүгээр би нэг л жишээ ярилаа. Энэ мэтчилнээр ярьж болохоор юмнууд олон байгаад байгаа юм. Наад усны асуудал цөлжилтийг бууруулах асуудал энэ тэр гээд олон юм ярьж болохоор. Би тэгээд ажлын хэсэгтээ хэлмээр байна л даа. Энэ тогтоолыг хэдүүлээ нэг сайн ярилцаад Засгийн газарт аа нэг бариад ажиллачих удирдлагын баримт бичиг болсон ийм шийдэл болгоод гаргачихвал цаашдын ажил амьдралд их тодорхой хэрэгтэй юм.

Ерөнхийдөө нэг тийм нийтлэг яригдаад байдаг их бүдүүлгээр яривал жижүүрийн маягтай нэг ийм заалтуудаар хөөцөлдөмгүй байгаад байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд жоохон нарийсгаж юмнуудаа орж тэгээд тэр талаасаа асуудалдаа харж ингэж л шийдвэрээ гаргавал амьдралд хэрэгтэй юм уу.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Гишүүдийнхээ бас саналыг бас хүлээж авч байна аа. Ажлын хэсгийн зүгээс бас тодорхой бас илүү сайжруулах ийм зүйлүүд бас байгаа талаар би ажлын хэсгийн даргад сая уламжиллаа. Гишүүдийн хувьд бас нэлээн нарийвчлах шаардлагатай юмнууд бас байна гэдэг энэ саналыг хэллээ. Тэгэхээр яах вэ өнөөдөр ямар ч байсан хэлэлцэж байгаа нь илүү нарийвчлах тодорхой саналууд гаргах гэдэг энэ агуулгаараа зөв болов уу гэж бодож байна.

Тэгэхээр өнөөдрийн гаргасан энэ төсөл дээр илүү тулгуурлаад цаашдаа илүү Засгийн газарт тодорхой яг барьцтай ийм саналуудыг оруулах чиглэлээр байнгын

хорооныхоо гишүүдийг бас саналыг тусгаад бас дахин боловсруулж оруулж ирье гэсэн ийм байдлаар ахлагчтайгаа бас зөвлөлөө.

Тийм учраас дэлгэрүүлээд өөр яг тодорхой саналуудыг Байнгын хорооны гишүүдээсээ аваад бид бүхэн дахиад ажиллая аа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ажлын хэсгийн дарга ч байхгүй байна. Байгаль орчны яамны улсууд ч байхгүй байна. Тэгээд ажлын хэсгийн ахлагч танилцуулж байгаа гишүүнээс санал гарч байгаа учраас энэ асуудлыг хойшлуулъя яасан гэсэн саналтай байна? 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ байгаль орчны чиглэлээр бас сая Батжаргал гишүүний юугаар суурь асуудал дээр нэг анхаарал тавиад ажиллахгүй бол энэ дээр олон хөтөлбөр хэрэгжиж байгаа. Жишээлбэл одоо тусгай хамгаалалттай газрын чиглэл дээр чинь 192 сая билүү тийм долларын төсөл хэрэгжээд тэр нь 79 сая доллар нь ирчихсэн байгаа. Гэтэл хаана хэрэгжиж байгаа нь тодорхой. Жишээ нь Сангийн яамныхан тодорхой хариулж чадахгүй л байна л даа энийг чинь. Тэгэхээр энэ асуудлыг хойшлуулаад дараа нь ажлын хэсэг гаргаад нарийвчлан шалгах, ажлын хэсэг үргэлжлээд ажиллаад тэгээд энийг хойшлуулж байгаад дараа нь танилцуулъя гэсэн, хойшлуулбал яасан юм гэсэн саналтай байна?

Гишүүд ямар саналтай байна? Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Би бүр ингэмээр байна. Энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг өөрсдөө хуралдаж хуралдаж л гаргаж ирж байгаа зүйл нь энэ шүү дээ. Шийдэж байгаа зүйл нь. Би бол энэ ажлын хэсгийг шинэчилж байгуулаасай гэж хүсэж байна. Одоогийн байгаа ажлын хэсгээс ахиж юм гарч ирнэ гэдэгт би итгэхгүй байна.

Түрүүн Батжаргал гишүүн хөндсөн хүлэмжийн хийн зах зээлтэй холбоотой энэ Сангийн яам ерөөсөө хуурай орж ирээд байгаа байхгүй юу. Та нар юугаа ч мэдэхгүй байна. Жишээлбэл ССРСС хүлэмжийн хийн зах зээл дээр ажиллаж байгаа 3.8 сая доллар үрчихсэн. Хаана яг асуудал байгаа гээч. Тэр 3.8 сая доллар үрэхдээ аль хэзээний Монгол Улс хүлэмжийн зах зээлийн судалгаа тооцоо бүх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэмжээний ажлыг хийчихсэн байх ёстой ажил байхгүй юу. Гэтэл тэнд юу болсон бэ гэхээр байгаль орчных нь өмнө нь сайдаар ажиллаж байсан өмнө нь гэдэг нь нэлээн 1990-ээд оных шүү. Сайдаар ажиллаж байсан хүн нь ТББ байгуулаад охиныхоо нэр дээр ингээд тэр ССРСС-ийн төсөл дампуурсан байхгүй юу. Ийм л зүйлийг бид нар гаргаж ирээсэй гэж хүсэж байгаа юм.

Энийг Сангийн яам ерөөсөө мэдэхгүй байна л даа. Та нар ажил руугаа орохгүй байна. Зүгээр сайхан илж байна. Тэгээд энэ хаашдаа энэ олон улсын төсөл хөтөлбөртэй холбоотой хэрэгжилттэй холбогдолтой энэ ашиглалттай холбогдолтой үлдэгдэл хөрөнгөтэй холбоотой асуудлууд тэгээд ялангуяа энэ олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой асуудлыг бол маш сайн ажлын хэсэг гаргаж яг хамаг шүүсийг нь шахаж оруулж ирэхгүй бол хий болох гээд байгаа байхгүй юу, хийсвэр. Энэ ямар ч үр дүн гарахгүй Засгийн газар ч ямар ч чиглэл өгөөд нэмэргүй. Яагаад гэвэл яаман дотор чинь хулгай байна. Тэн дотор өмнө нь сайдаар ажиллаж байсан эрх мэдэлтэй албан тушаалтнуудын үр хүүхдүүд нь ТББ байгуулаад тэгээд хүлэмжийн зах зээл дээр ажиллаж байгаа. Өнөөдөр тэр сайдаар ажиллаж байсан хүн одоо ч байгаа. Тэгээд энэ гэх мэтчилнээс авхуулаад ийм асуудлууд руугаа орж

энэ ажлын хэсэг ажилламаар байгаа юм аа. Энэ ажлын хэсэг ингэж орж ажиллахгүй бол цаашдаа явахгүй. Би жишээлбэл сайдаар ажиллаж байх үед БОАЖЯ-ан дээр 24 төсөл хөтөлбөр 170-аад сая долларынх байсан шүү дээ. 170-аад сая долларын хөрөнгө, 24 төсөл хөтөлбөр байсан. Нэг ч юм нь энэ дотор орж ирэхгүй байна шүү дээ. Жишээлэх юм бол. Тэгэхээр гэх мэтчилэнгээс авхуулаад энэ яг нарийн асуудлууд руу энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсэг орж ажиллаасай. Худлаа хийсвэр байдлаар ийм илсэн байдалтай өөх ч биш, булчирхай ч биш нэг ийм юмыг Ганбаатар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гаргасан байна. Энэ маш хангалтгүй байна гэж би бодож байна.

Би бүр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчилмөөр байна. Жоохон зоригтой энэ Ганхуяг гишүүнээр ахлуулаад тавьчихгүй юу. Жишээлэх юм бол.

Тэгэхгүй бол энэ ажлууд чинь явахгүй. Бие биеийнхээ хулгай луйврыг хуурсаар нүдийг нь угаасаар л явна. Ний нуугүй хэлэхэд.

Б.Бейсен: Энэ гишүүдийн саналыг дэмжиж байна. Энэ ажлын хэсэг дахиж хуралдаад энэ тогтоолын үндэслэлээ сайн гаргаад оруулж ирэх шаардлагатай байна. Тийм учраас энэ хойшлуул гэсэн саналтай байна. Санал хураалт явуулъя, санал хураалтад бэлдээрэй.

Горимын санал хураалт. Санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт. Хойшлуулж санал хураалт.

Хойшлуулах санал хураалтын санал 56.3 хувиар дэмжигдсэн тул энэ асуудлыг хойшлуулах шийдвэр гарлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаанд оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

17.27 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА